



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2024 оны 02 сарын 29 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит
сонгуульд нам, эвсэл, нэр дэвшигчээс зарцуулах зардлын
дээд хэмжээ тогтоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.12, 29.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, "Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай" Монгол Улсын Их Хурлын 2023 оны 122 дугаар тогтоол, Сонгуулийн ерөнхий хорооны 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрогт нэр дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуульд нэг нам, эвслээс зарцуулах зардлын дээд хэмжээг 6,434.5 сая төгрөгөөр тогтоосугай.

3. Энэхүү тушаалаар тогтоосон зардлын дээд хэмжээг нийтэд мэдээлэхийг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор (Д.Энхболд)-т даалгасугай.

4. Энэхүү тушаалаар тогтоосон зардлын дээд хэмжээг цахим орчинд байршуулж олон нийтэд сурталчлахыг Захиргаа, хууль, эрх зүйн газрын дарга (С.Батбямба)-д даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга (Ц.Баярмаа)-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Д.ЗАГДЖАВ

Монгол Улсын Ерөнхий аудиторов
2024 оны 02 дугаар сарын 23 өдрийн
А/12 дугаар тушаалын хавсралт

**Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрогт нэг нэр
дэвшигчээс сонгуульд зарцуулах зардлын дээд хэмжээ**

Тойргийн дугаар	Тойргийн нутаг дэвсгэр	Зардлын дээд хэмжээ (сая төгрөгөөр)
1	Архангай, Баянхонгор, Өвөрхангай	1,379.0
2	Говь-Алтай, Завхан, Увс, Ховд	1,526.1
3	Баян-Өлгий	1,058.7
4	Булган, Орхон, Хөвсгөл	1,230.5
5	Дархан-Уул, Сэлэнгэ, Төв	1,064.3
6	Дорнод, Сүхбаатар, Хэнтий	1,164.9
7	Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь	1,098.5
8	Баянзүрх	1,164.5
9	Баянгол	1,099.7
10	Сүхбаатар, Чингэлтэй	894.8
11	Сонгинохайрхан	968.6
12	Хан-Уул	1,121.7
13	Багануур, Багахангай, Налайх	994.3